

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын
2022 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2023/5/НА-СТА-ОНА

| | |
|--|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2023 он</p> | <p>Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 7037-3089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 7037-3089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 7037-3089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Дундманхайдай аудит” ХХК Захирал : Ж.Бямбажав Цахим хаяг: dum_audit@yahoo.com Утас: 11-325262 Утас: 91991462</p> |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“ДАРХАН ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА
ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Д.БАТБАЯР ТАНАА

2023.01.15 № 161

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дархан-Уул аймгийн “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ- ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ- ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн захирагч нь байгууллагын хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж, хэмнэлтийн горимыг баримтлан, ажилласан байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 6 зорилтын хүрээнд 90 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлж ажиллахаас гүйцэтгэлээр 95 хувийн гүйцэтгэлтэй байна.

009020251

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

Дархан-Уул аймгийн Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын
2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---------------|------------------------------------|------------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 238,189,697.13 | 253,089,655.98 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 230,394,084.24 | 236,573,057.10 |
| 31200 | Банканд байгаа бэлэн мөнгө | 230,394,084.24 | 236,573,057.10 |
| 31210 | Төгрөг | 230,394,084.24 | 236,573,057.10 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 230,394,084.24 | 236,573,057.10 |
| 33 | АВЛАГА | 2,613,499.63 | 10,936,775.63 |
| 33401 | Дансны авлага /ТӨҮГ/ | 2,613,499.63 | 10,779,035.51 |
| 33402 | Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/ | 0.00 | 157,740.12 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 5,182,113.26 | 5,579,823.25 |
| 35400 | Хангамжийн материал | 5,182,113.26 | 5,579,823.25 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,182,113.26 | 5,579,823.25 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 31,698,977.11 | 60,129,737.37 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 31,698,977.11 | 60,129,737.37 |
| 39200 | Биет хөрөнгө | 30,678,977.11 | 59,669,737.37 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 25,000,000.00 | 44,850,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -9,027,777.81 | -15,675,694.48 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 24,656,146.00 | 51,950,946.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -16,406,468.42 | -26,205,084.84 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 17,425,616.50 | 17,425,616.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -10,968,539.16 | -12,676,045.81 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 1,020,000.00 | 460,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,640,000.00 | 2,640,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -1,620,000.00 | -2,180,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 269,888,674.24 | 313,219,393.35 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 48,704,353.91 | 40,295,405.32 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 48,704,353.91 | 40,295,405.32 |
| 41300 | Өглөг | 48,704,353.91 | 40,295,405.32 |
| 41360 | Бусад өглөг | 48,704,353.91 | 40,295,405.32 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,392,400.00 | 0.00 |
| 41363 | Татварын өглөг /ТӨҮГ/ | 27,360,271.91 | 40,295,405.32 |
| 41365 | Ноогдол ашгийн өглөг /ТӨҮГ/ | 19,951,682.00 | 0.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 221,184,320.33 | 272,923,988.03 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 221,184,320.33 | 272,923,988.03 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 18,193,545.00 | 18,193,545.00 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 21,458,827.00 | 21,458,827.00 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 181,531,948.33 | 233,271,616.03 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 102,636,536.03 | 16,531,948.33 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 78,895,412.30 | 216,739,667.70 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---------------|--|------------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 373,664,999.73 | 737,311,902.73 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 373,664,999.73 | 737,311,902.73 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 373,664,999.73 | 737,311,902.73 |
| 120009 | Бусад орлого | 1,614,363.63 | 8,118,105.00 |
| 120010 | Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/ | 372,050,636.10 | 729,193,797.73 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 294,033,462.43 | 520,572,235.03 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 294,033,462.43 | 520,572,235.03 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 293,524,372.34 | 520,572,235.03 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 125,679,932.00 | 161,384,657.00 |
| 210101 | Үндсэн цалин | 125,679,932.00 | 161,384,657.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 15,743,050.09 | 19,988,246.51 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,743,050.09 | 19,988,246.51 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 9,854,227.27 | 7,971,418.17 |
| 210304 | Байрны түрээс | 9,854,227.27 | 7,971,418.17 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 14,655,736.81 | 19,811,038.23 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,026,481.77 | 2,481,727.27 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,431,181.82 | 16,409,090.91 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 385,345.50 | 515,901.91 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 812,727.72 | 404,318.14 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,254,909.05 | 1,277,181.82 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 0.00 | 1,277,181.82 |
| 210604 | Урсгал засвар | 2,254,909.05 | 0.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 276,000.00 | 1,008,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 276,000.00 | 1,008,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 113,057,483.77 | 290,417,153.56 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 82,734,449.71 | 253,308,414.39 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 78,980.00 | 80,200.00 |
| 210813 | Бусад зардал /ТӨҮГ/ | 21,657,270.87 | 13,848,365.54 |
| 210814 | Орлогын татварын зардал /ТӨҮГ/ | 8,586,783.19 | 23,180,173.63 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,003,033.35 | 18,714,039.74 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 12,003,033.35 | 18,714,039.74 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 509,090.09 | 0.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 509,090.09 | 0.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 509,090.09 | 0.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 79,631,537.30 | 216,739,667.70 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 736,125.00 | 0.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 736,125.00 | 0.00 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 78,895,412.30 | 216,739,667.70 |

Дархан-Уул аймгийн Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын
2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---------------|--|------------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 410,702,285.41 | 798,178,751.50 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 410,702,285.41 | 798,178,751.50 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 410,702,285.41 | 798,178,751.50 |
| 120009 | Бусад орлого | 70,000.00 | 75,900.00 |
| 120013 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/ | 409,999,672.41 | 790,289,857.50 |
| 120015 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө /ТӨҮГ/ | 632,613.00 | 84,889.00 |
| 120016 | Буцаан авсан албан татвар /ТӨҮГ/ | 0.00 | 7,728,105.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 302,571,257.79 | 574,903,296.64 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 302,571,257.79 | 574,903,296.64 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 302,571,257.79 | 574,903,296.64 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 102,065,403.00 | 135,112,995.00 |
| 210101 | Үндсэн цалин | 102,065,403.00 | 135,112,995.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 30,431,118.17 | 37,760,371.68 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 30,431,118.17 | 37,760,371.68 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 10,458,440.00 | 7,672,091.81 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | 10,458,440.00 | 7,672,091.81 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 17,751,533.00 | 27,530,100.00 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/ | 12,624,900.00 | 14,012,700.00 |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/ | 5,126,633.00 | 13,517,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 141,864,763.62 | 366,827,738.15 |
| 210816 | Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 27,628,857.62 | 76,251,830.15 |
| 210817 | Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 234,010.00 | 490,900.00 |
| 210818 | Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/ | 114,001,896.00 | 290,085,008.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 108,131,027.62 | 223,275,454.86 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 344,900.00 | 47,144,800.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 344,900.00 | 47,144,800.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 344,900.00 | 47,144,800.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 0.00 | 47,144,800.00 |
| 225101 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/ | 344,900.00 | 0.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -344,900.00 | -47,144,800.00 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -8,026,372.00 | -169,951,682.00 |
| 25 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 8,026,372.00 | 169,951,682.00 |
| 250005 | Төлсөн ногдол ашиг | 8,026,372.00 | 169,951,682.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 99,759,755.62 | 6,178,972.86 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 130,634,328.62 | 230,394,084.24 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 230,394,084.24 | 236,573,057.10 |

Дархан-Уул аймгийн Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын
2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-----------------------|--|
| 1 | 2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 39,652,372.00 | 0.00 | 122,588,218.03 | 162,240,590.03 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 39,652,372.00 | 0.00 | 122,588,218.03 | 162,240,590.03 |
| 8 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | -19,951,682.00 | -19,951,682.00 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 78,895,412.30 | 78,895,412.30 |
| 10 | 2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 39,652,372.00 | 0.00 | 181,531,948.33 | 221,184,320.33 |
| 11 | 2022 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл | 39,652,372.00 | 0.00 | 181,531,948.33 | 221,184,320.33 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 39,652,372.00 | 0.00 | 181,531,948.33 | 221,184,320.33 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | -165,000,000.00 | 165,000,000.00 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 216,739,667.70 | 216,739,667.70 |
| 20 | 2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 39,652,372.00 | 0.00 | 233,271,616.03 | 272,923,988.03 |

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2021 оны гүйцэтгэл | 2022 оны | | Зөрүү | Хувь |
|---|---|-------------|--------------------|----------------|----------------|----------------|--------|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт | | | | | | |
| 2 | Нийт орлого | төгрөг | 373,665,000.00 | 630,000,000.00 | 737,311,902.73 | 107,311,902.73 | 117.0 |
| | Үүнээс: Цэвэр борлуулалт | төгрөг | 373,665,000.00 | 630,000,000.00 | 729,193,797.73 | 99,193,797.73 | 115.7 |
| | Бусад орлого | төгрөг | | | 8,118,105.00 | 8,118,105.00 | - |
| 3 | Нийт зардал | төгрөг | 373,665,000.00 | 630,000,000.00 | 37,311,902.73 | 107,311,902.73 | 117.0 |
| | Үүнээс: | төгрөг | | | | 0.00 | - |
| | а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | төгрөг | | | | 0.00 | - |
| | б) Ерөнхий ба удирдлагын зардал | төгрөг | 285,446,700.00 | 618,910,886.00 | 520,572,235.03 | -98,338,650.97 | 84.1 |
| | в) Үндсэн хөрөнгө данснаас хассан олз, гарз | төгрөг | 736,100.00 | 0 | | 0.00 | - |
| 4 | Цэвэр ашиг, алдагдал | төгрөг | 87,482,200.00 | 11,089,114.00 | 216,739,667.70 | 205,650,553.70 | 1,954. |

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8,777.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 8,777.3 мянган төгрөгийн төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Татварын өглөг 8,777.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд зарим байгууллагуудтай гэрээ, тооцоо нийлсэн акт хийгээгүй өр төлбөр баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" заалт Эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өр төлбөрийн тооцоог барагдуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 1 - ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган
төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|---------|------------------|-----|--------------------|-----|---------|---------|--|---------------------------|--|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тайлант онд өр төлбөр тооцоо нийлж барагдуулаагүй | 1 | 8,777.3 | | | | | 1 | 8,777.3 | - | - | - | - |
| | | | | | | | | | - | - | - | - |
| Дүн | 1 | 8,777.3 | | | | | 1 | 8,777.3 | - | - | - | - |